



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 487

Улаанбаатар хот

Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Засгийн газрын 10 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.3, 6.4.3, 6.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн Боршоо боомтын дахин төлөвлөлт, шинэчлэлийн ажилтай холбогдуулан ТОГТООХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын харьяа Увс аймаг дахь Гаалийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 11 нэрийн, нийт 212,998,941.00 (хоёр зуун арван хоёр сая есөн зуун ерэн найман мянга есөн зуун дөчин нэгэн) төгрөгийн балансын үнэ, 156,063,505.30 (нэг зуун тавин зургаан сая жаран гурван мянга таван зуун таван төгрөг гучин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Гаалийн ерөнхий газрын дарга С.Асралт, Увс аймгийн Гаалийн газрын дарга Д.Төмөр-Өлзий нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан барилгыг акталж, данснаас хасах, барилгыг буулгаж хоёрдогч түүхий эд болгон ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Боомтын барилга буулгаж, чөлөөлсөн газрыг байгууллагын хилийн боомтын барилга байгууламжийн зориулалтаар нь ашиглах, газрыг нөхөн сэргээх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2020 оны 10
дугаар сарын 15-ны өдрийн
487-дугаар тогтоолын хавсралт

**Увс аймгийн Гаалийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Боршоо боомтын
актлах үндсэн хөрөнгийн жагсаалт**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиг лалтад орсон он	хэм жих нэгж	Балансын үнэ (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл өртөг (төгрөгөөр)
1	Орон сууц-2 айл	1990	ш	4,774,321.00	2,348,966.00	2,425,355.00
2	Орон сууц 2 айлын	1987	ш	4,896,892.00	4,437,127.50	459,764.50
3	Боршоо тал граж	2005	ш	161,000.00	135,239.76	25,760.24
4	Нохойны байр	2011	ш	400,000.00	400,000.00	0.00
5	ШНБ контор боршоо	1996	ш	47,571,400.00	29,771,767.22	17,799,632.78
6	ажлын байр хуучин контор	1987	ш	2,840,065.00	2,495,670.88	344,394.12
7	агуулах 200м2	1996	ш	10,140,215.00	6,346,102.68	3,794,112.32
8	авто пүүний байр	2003	ш	7,000,028.00	6,994,194.37	5,833.63
9	үерийн хамгаалалт	1997	ш	27,590,020.00	27,590,020.00	0.00
10	төмөр хашаа зам талбайн өргөтгөл	2008	ш	105,080,000.00	73,466,000.22	31,613,999.78
11	саун	2008	ш	2,545,000.00	2,078,416.67	466,583.33
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН			212,998,941.00 (хоёр зуун арван хоёр сая есөн зуун ерэн найман мянга есөн зуун дөчин нэгэн)	156,063,505.30 (нэг зуун тавин зургаан сая жаран гурван мянга таван зуун таван төгрөг гучин мөнгө)	56,935,435.70 (тавин зургаан сая есөн зуун гучин таван мянга дөрвөн зуун гучин таван төгрөг далан мөнгө)